

**“Хай Би Ойл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022.04.29-ны өдрийн ээлжит хурлын
тэмдэглэл**

2022.04.29

Улаанбаатар хот

“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 сарын 29-ны өдрийн 10 цаг 05 минутанд Чингэлтэй дүүрэг 3 дугаар хороо Жуулчины гудамж-34, Pearl tower барилга, В корпус 9 давхар 1 тоотод эхлэв.

Хуралд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал Ш.Амар-Отгон, Нягтлан бодогч О.Ганчимэг хурал зохион байгуулах комиссын гишүүн Н.Батнайрамдал, нар мөн нийт 3 хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар, 2 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр оролцов.

Хурлын дарга Ш.Амар-Отгон: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа “Хай Би Ойл” ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээсэнийг мэдэгдье.

Ингээд “Хай Би Ойл” ХК-ийн 2022 оны 04 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг та бүхэнд танилцуулъя. Нийт 52,118,954 хувьцаанаас нийтдээ 88,9% буюу 46,362,430 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хурлын ирц бүрдсэн тул хуралаа эхлэж байна.

Өнөөдрийн хурлыг “Хай Би Ойл” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Амар-Отгон миний бие даргалах бөгөөд хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэг, компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэлийг өгнө.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулж, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
4. Компанийн ногдол ашиг хуьмарлахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл /мэдээлэл тул санал хураахгүй./

Миний бие “Хай Би Ойл” ХК-ийн Гүйцэтгэх захиралаар 4 дахь жилдээ ажиллаж байгаа Ш.Амар-Отгон гэж хүн байна. Бид 2021 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг та бүхэнд танилцуулна. Би үйл ажиллагааныхаа тайланг ерөнхийд нь танилцуулна. Манай нягтлан бодогч О.Ганчимэг санхүүгийн тайлан, аудитын тайланг танилцуулах болно.

“Хай Би Ойл” ХК 2007 оноос хойш “Аюултай хог хаягдал” буюу техникийн ашигласан хаягдал төс цуглуулаад түүнийгээ дахин боловсруулж Мазут M100 гэдэг бүтээгдэхүүнийг

үйлдэвэрлэдэг үйлдвэр байгаа юм. Манай компани нь нийт 8 ажилчинтайгаар үйл ажиллагаа явуулдаг.

2021 онд “Хай Би Ойл” ХК нь ковидын нөхцөл байдлын улмаас ерөнхийдөө үйл ажиллагаа маань зогсонги байдалтай хэвийн бус ажилласан байгаа.

Борлуулалтын тухайд: 2021 онд нийт 135 000 000 /нөат орсон үнэ/ сая төгрөгийн борлуулалт хийсэн. Энэхүү борлуулалт маань 3 компанитай гэрээ байгуулагдан хийгдсэн. Гэрээний нийт дүн өндөр дүнтэй байсан боловч худалдан авагч компаниудын нөхцөл байдал хүндэрч зарим компаниудын үйл ажил зогссоноос болж гэрээний дагуу нийлүүлэх мазутаа өгч чадаагүй. “Наранбулаг хан” ХХК, “Арж рөүл” ХХК, “Блүүм ойл” ХХК гэсэн 3 компанид нийтдээ 200.0 тонн мазутыг 135 000 000 /нөат орсон үнэ/ сая төгрөгөөр борлуулалт хийсэн. Өмнөх онын түүхий эдийн үлдэгдэл 480 873 литр, боловсруулсан мазут нь 137 000 байсан үүнээс 200 тонныг л борлуулсан байгаа. 2021 оны тайлант хугацаанд ажил үйлчилгээ үзүүлэх 1 гэрээ байгуулсан нь СХД-ийн татварын тохижилт үйлчилгээ цэвэрлэгний төвтэй байгуулсан гэрээ юм. Бусад гэрээнүүд бол хаягдал түүхий эд цуглуулах гэрээ 13 газартай байгуулсан. 2021 онд манай компанийн хувьд бусад компаниутай адил ковидын нөхцөлөөс болоод борлуулалт муу үйл ажиллагаа удааширалтай байсан.

Манай бүтээгдэхүүнийг Дулааны Цахилгаан Станцууд болон авто замын компаниуд нь галлагааны түлшний зориулалтаар ашигладаг. Аюултай хог хаягдал цуглуулах дахин боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбогдуулаад Байгаль Орчны Яамтай салшгүй холбоотой ажилладаг. Байгаль Орчны Яаманд хийж байгаа үйл ажиллагааны ажлын тайлан болон, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө жил бүр гаргаж өгөөд хянуулж батлуулдаг. Холбогдох тайлангуудыг цаг хугацаанд нь баталгаажуулж явсан. Тайлант хугацаанд компанийн зүгээс хийгдэх болон хийх ёстой ажлууд бүгд хийгдсэн. Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн болох мазутаа жилд 1-2 удаа Газрын тосны бүтээгдэхүүн шинжлэх итгэмжлэгдсэн лаборатори болох “Амбер” ХХК-д шинжилгээ хийлгэдэг байгаа.

Компанийн ажлын байр нь 40 тоннын контайнерыг засаж янзлаад оффис болгон байрлаж ажилдаг. Энэ байрны 2 тасалгааг нэгтгээд нэг том өрөө болгон янзалсан. Энэхүү засвар хийхтэй холбоотой зардалыг бид компаниас гаргаагүй бөгөөд Байгаль Орчны Яамнаас олгодог байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг мөн байгальд орчинд ээлтэй дэвшилтэт төнөг төхөөрөмж нэвтрүүлсэн ААН байгууллагад олгодог “Ногоон гэрчилгээ” шагналаар шагнагдаж, шагналыг дагалдаж 2 000 000 сая төгрөг өгсөн. Энэ шагналын мөнгөөрөө оффисоо засварлаж дуусгасан байгаа. Мөн Ажилчидын унаа машин техник хэрэгсэлүүдийн урсгал засвар, оношилгоо үйлчилгээнүүдийг цаг хугацаанд нь хийлгэж даатгал татварыг төлсөн. Хаягдал тос буюу түүхий эдээ цуглуулдаг тээврийн хэрэгсэл маань хот дотор зөвшөөрөл авч явдаг бөгөөд тэрхүү зөвшөөрөлийг 2 том машиндаа хагас жилийн хугацаатайгаар авсан.

Мөн агаарт үүсэх тоосжилт болон хөрсийг хамгаалах чиглэлийн дагуу үйлдвэрийн хашаан доторхи талбай болон хог ачих цэгийн суурь, ажилчидийн байр, үйлдвэрийн барилгын урд хэсэг мөн тос асгарч болзошгүй агуулах савны буулгадаг талбайн хэсгүүдийг бүгдийг нь хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлж бетондож, хортой хэсгийг нь саармагжуулах ажлыг хийсэн.

Манай компани цахилгааны КТП 630-ын трансматор ажиллуулдаг бөгөөд жил бүр аюулгүй байдлын үүднээс хариуцдаг мэргэжилийн хүмүүсээр тосыг нь шалгуулж, солиулж урсгал засвар хийлгүүлсэн байгаа. Ажилчидийн угаалгын өрөө, угаалтуур, хувцас угаах угаалгын машин болон усанд орох шүршүүрийг байрлуулах зэрэг тохижилтын ажилууд хийгдсэн.

Компанийн үйлдвэрийн хаягжилтийн нэршил өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2008 онд авсан газар эзэмших гэрчилгээг СХД-ийн газрын албанаас шинээр авсан.

Монголын хог хаягдалыг дахин боловруулах үндсэний холбоотой “Хай Би Ойл” ХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш хамтран ажиллаж байгаа бөгөөд энэ байгууллагын гишүүн байгууллага юм. Хог хаягдлын холбооноос аюултай хог хаягдлын мэргэжилийн холбооны нэгдсэн сургалт болж манай хамт олон бүгд хамрагдсан. Манай үйлдвэрээс түүхий элээ боловсруулах явцад хаягдал ус гэж гардаг тэр усыг хаяж болох эсэхийг усны төвийн лаборторт шинжилгээ өгөөд хаяж болох зөвшөөрөлийг мөн авсан байгаа.

“Хай Би Ойл” ХК-ийн үйл ажиллагааны хүрээнд бол жил бүр хийгдэх ёстой ажилууд дээрхи ярьсанчлан бүгд хийгдсэн.

Борлуултын хувьд 3 компанитай гэрээ хийгдсэн боловч гэрээ хийгдсэний үнийн дүнгийнхээ дагуу хэрэгжээгүй, 1 компанийн авсан ажил нь цуцлагдсан, 1 компани нь өөр компаниас хямд үнээр бүтээгдэхүүнээ авсанаас борлуулалт энэ жил муу байсан.

“Хай Би Ойл” ХК нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа гаргаад “Эвиденсе Аудит” ХХК-аар аудит хийлгэсэн. 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангын талаар нягтлан бодогч О.Ганчимэг танилцуулна.

“Хай Би Ойл” ХК-ийн нягтлан О.Ганчимэг: “Хай Би Ойл” ХК-ийн нягтлан бодогч О.Ганчимэг байна. Хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Миний бие энэ компанид 12 дахь жилдээ ажиллаж байна. 2021 оны тайлангийн үзүүлэлтүүдийг танилцуулая.

2021 онд нийт орлого бол НӨАТ-гүй дүнгээрээ 133,363.0 төгрөгийн борлуулалтын орлоготой, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 82,967.2 тогрог, борлуулалтаасаа 50 000 000 сая төгрөгийн ашигтай байгаа түүн дээр хүүгийн орлого 151 000 төгрөг энэ нь шатахууны картын урамшуулал юм. Бусад орлого гэдэг нь манай компани хашаан дотроо 2, 3 машин байрлуулан тавиулсаны түрээсийн төлбөр нь орлого гэж орж ирсэн юм. Нийт орлогоосоо ерөнхий удирдлагын зардал 301,719.3 төгрөгийг хасахаар бусад зардалд 7,483.1 төгрөг болсон байна. 2021 онд манай компани нь 257 сая төгрөгийн алдагтай ажилласан.

Гарсан зардалууд:

1. Цалингийн зардалд	127,455.3₮
2. НДШ-д	15,312.6₮
3. Ашиглалт болон урсгал засвар үйлчилгээнд	8,242.1₮
4. Албан татварт	7,294.2₮
5. Түлш шатахуун тээвэрт	20,072.3₮
6. Элэгдэл, хорогдлын зардал	100,927.2₮
7. Шуудан холбоо, бичиг хэрэг, мэргэжлийн үйлчилгээнд	22,415.6₮

8. Бусад зардалд

7,483.1₮

- Өмнөх оны авлага 2,375,898.1 төгрөг, дансны өглөг 159,040.7 төгрөг байна.

Алдагдал яаж үүссэн гэхээр 2020 оны 1 дүгээр сарын сүүлээр ковид үүсээд ковидоос болоод ерөнхийдөө бусад компаниудын үйл ажиллагаа хэцүү хүнд байдалд орсон. 2020 онд “Дэвжих-эрдэнэ” ХХК-д хийсэн борлуулалтын 124 сая төгрөг төлөгдөхгүй удаанхирсан тул шүүхэд хандаад одоо шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр явж байна. 124 сая төгрөгийн өглөгнөөс өнөөдрийн байдлаар 15 сая төгрөгийг л авсан. За та бүхнээс асуух зүйл байвал асуугаарай.

Ногдол ангийн тухайд: ТУЗ-ын ногдол ашиг тараахгүй гэсэн шийдвэрийг танилцуулья аа. Компанийн 2021 оны 12 сарын 31-ны үлдэгдэлээр 257 сая төгрөгийн алдагдалтай ажилласан учраас ногдол ашиг тараах боломжгүй гэж үзээд ногдол ашиг тараахгүй гэсэн шийдвэр гарсан байгаа шүү.

Хувьцаа эзэмшигч С.Уранчимэг: Миний бие өчигдөр “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчийн хуралд оролцсон тэр хурал дээр танай компанийг өөрийнхөө компанийн хөрөнгө оруулагч болсон гэсэн тэр ямар учиртай вэ?

“Хай Би Ойл” ХК нь “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигч болсон. Энэ нь ямар учиртай вэ гэхээр “Шарын гол” ХК манай компанид өртэй байсан. Энэхүү өрөө төгрөгөөр төлөх боломжгүй байсан учраас бид хувьцааг нь өрөндөө тооцож авсан. “Шарын гол” ХК-аас 2,2 тэрбум төгрөгний авлагатай байсан ба өрөө хувьцаанд шилжүүлж өгснөөр “Шарын гол” ХК-ийн 18%-ийн хувьцаа эзэмшигч болсон.

Өнгөрсөн онд борлуулалт муу байсан учраас борлуулалтаа өсгөх үүднээс манай компани 2021 оны 9 сараас эхлээд тендерт оролцож эхэлсэн. 3 удаа тендерт оролцсон боловч шалгараагүй байгаа. Доорх тендерүүдэд оролцсон Үүнд:

1. Дорнод аймгийн Дорнод Бүсийн Цахилгаан Станцаас зарласан тендерт оролцсон. /Энэ тендерт 240.0 тонн мазут нийлүүлэхээр оролцсон боловч шалгараагүй. Тендер зарласан газраас дотоодын компаниудад давуу эрх олгоно гэсэн боловч түүнийг тооцоогүй мөн тус тендерт 3 компани өрсөлдсөн бөгөөд нэг компани нь манай компанийн “Амбер” ХХК-д өгсөн шинжилгээний бичгийг ашиглаж ороод ялсан байсан тул бид Сангийн Яаманд гомдол гаргаж тэр тендерийг хүчингүй болгосон./
2. Эрдэнэтийн Цахилгаан Станцад мазут нийлүүлэх тендерт оролцсон. Энэ тендерт 30.0 тонн мазут нийлүүлэх байсан мөн шалгараагүй.
3. Дээрх Дорнод Бүсийн Цахилгаан Станцаас дахин зарлаад оролцсон боловч техникийн тодорхойлолтын нэг үзүүлэлт буюу шинжилгээгээр манай бүтээгдэхүүний зууралдлага бага байна гэдэг үндэслэлээр мөн шалгараагүй. Дээрх тендерүүдэд шалгарч чадсан бол тодорхой хэмжээгээр борлуулт маань өсөх байсан.

Улаанбаатар хотод аюултай хог хаягдал дахин болосруулах цуглуулах тээвэрлэх цорын ганц тусгай зөвшөөрөлтэй компани юм, Улаанбаатар хотод авто засварын үйл ажиллагаа явуулдаг ихэнх компаниудтай гэрээ байгуулан хаягдал тосыг нь цуглуулдаг байгаа.

Хувьцаа эзэмшигч С.Уранчимэг: Цахилгаан станцуудаас түүхий эд гардаггүй юмуу

Үгүй ээ, түүхий эд зөвхөн авто засварын газрууд болон уул уурхайн компаниудаас гардаг байгаа. Бид хаягдал тосыг дахин боловсруулаад мазут гаргаж аваад түүнийгээ харин цахилгаан станцуудад нийлүүлэх бүтээгдэхүүн боловсруулдаг байгаа юм. Бүтээгдэхүүнээ станцуудад нийлүүлэхийн тулд заавал тендерт оролцож шалгарч байж нийлүүлдэг байгаа. Тийм болохоор бид тендерт оролцсон боловч шалгараагүй голдуу ОХУ-с оруулж ирдэг мазут ашигладаг юм байна лээ. За ингээд өөр асуух зүйл байхгүй бол санал аваад дүнг танилцуулая

Хурлын төгсгөлд хурлын дарга Ш.Амар-Отгон тооллогын гишүүдээс ирсэн санал хураалтын дүнг танилцуулав:

Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 88,9 % буюу 46,362,430 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас ирснээс 88,9 % буюу 100% хүчинтэй байлаа.

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

2. Компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулж, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% нь зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

3. Компанийн шинэ ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдээс Т.Батгэрэл 16.6%, Б.Дөлгөөнтамир 16,06%, С.Одгэрэл 16.6%, Б.Пүрэвбаатар 16.6%, Р.Оюунбат 16.6% Н.Гүнжидмаа 16.6-ийн санал авч ердийн гишүүдэд сонгогдлоо.

Хараат бус гишүүдэд А.Харцага 33.3%, Т.Тамир 33.3%, Ж.Болорцэцэг 33.3%- ийн саналтайгаар сонгогдлоо.

“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны хуралд маань цаг заваа гарган оролцсон Та бүхэндээ баярлалаа.

Хурал 11:10 өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА:



Ш.АМАР-ОТГОН

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: Н.БАТНАЙРАМДАЛ